

## Санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

### НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 09 сарын 15-ны өдрийн 1/16 дугаар удирдамжийн дагуу Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эрүүл мэндийн тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун би 2022 оны 09 сарын 24-ний өдрөөс хуанлын 7 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэв.

### ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, хүнсний бүтээгдэхүүн, эм, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

### ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Тэшиг сумын тавдугаар багт байрлах 9013865 регистрийн дугаартай Эрүүл мэндийн төв нь байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандарт технологийн дагуу үзүүлж, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх зорилгыг дэвшүүлсэн байна.

Тус сумын Засаг даргын 2021 оны 02 сарын 09-ний Б/07 дугаар, сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 01 сарын 27-ны өдрийн А/01 дугаар “Бүтэц, орон тоог батлах тухай” шийдвэрээр дарга 1, эмчлэгч эмч 3, эх баригч бага эмч 1, дүн бүртгэгч бага эмч 1, нийгмийн эрүүл мэнд хариуцсан бага эмч 1, вакциатор 1 (уламжлалт, чийрэгжүүлэлтийн сувилагч хавсрах), ахлах сувилагч 1, ээлжийн сувилагч 4, багийн бага эмч 4, багийн сувилагч 1, лаборант 1, тогооч 1, нягтлан бодогч 1, жолооч 1, нярав (слесарь) 1, ариутгагч (архив, бичиг хэрэг) 1, үйлчлэгч 3 нийт 27 орон тоотой ажиллахаар баталсанаас ЭМТөвийн дарга (их эмч хавсран) 1, их эмч 2, эх баригч бага эмч 1, статистикч эмч 1, нийгмийн эрүүл мэнд хариуцсан бага эмч 1, багийн бага эмч 4,

вакцинатор сувилагч 1, ахлах сувилагч 1, сувилагч 5, лаборант 1, тогооч 1, нягтлан бодогч 1, жолооч 1, ариутгагч бичиг хэргийн ажилтан 1, нярав 1, үйлчлэгч 3 нийт үндсэн 26 орон тоотойгоор ажилласан байна.

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 01 сарын 01-ээс 2022 оны 12 сарын 31-ний өдөр хүртэлх санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг Ц.Алтантуяа, хоёрдугаар гарын үсгийг Б.Оюунбямба нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 100041020001 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100041020401 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг “СТS” программаар бүртгэн хөтөлжээ.

Нярав эд хариуцагчаар Б.Чинтэр ажилласан байна.

### **ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас тус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “**хязгаарлалттай**” санал дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 26,260.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 25,145.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага хүргүүлж, 1,115.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн ба албан шаардлагын хариуг хугацаанд нь албан бичгээр хүргүүлсэн байна.

Үүнд: Илэрсэн алдаа, зөрчил: Эм болон хүнсний материалын тодруулга тайланг няравын тайлантай тулгахад нийт орлого 107,825.6 мянган төгрөг, зарлага 20,151.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, НДШ, ХХОАТ-ын өглөгийг шууд НДШ-ийн цалингийн өглөг данс руу нийт 4,994.6 мянган төгрөгийн журналын бүртгэл дутуу хөтөлж өглөгийн дансаар дамжуулалгүй тайлагнасан, тайланд хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 1,115.2 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн, жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комисс томилогдоогүй бөгөөд үндсэн хөрөнгийг 430,477.9 мянган төгрөгөөр буюу үлдэх өртөгөөр тооцсон, шилэн дансанд гуравдугаар улирлын төсвийн гүйцэтгэлийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21 удаагийн 319,409.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй.

### **ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Тэшиг сумын Эрүүл мэндийн төв нь шилэн дансны цахим хуудсанд **2021 онд** мэдээлбэл зохих 161 мэдээллээс 158 мэдээллийг тогтоосон хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож, бусад цэснээс 2-р сард мэдээлэх 1 мэдээллийг огт мэдээлээгүй.

Мэдээлэл байршуулсан байдлыг шалгахад; өмч хөрөнгөтэй холбоотой 31 шийдвэр гарсанаас 5 шийдвэрийг байршуулж, 26 шийдвэрийг огт байршуулаагүй.

**2022 оны 1-8-р сард** мэдээлбэл зохих 109 мэдээллээс 105 мэдээллийг тогтоосон хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 24 шийдвэрээс 19 шийдвэр байршуулаагүй байна.

### **ДОЛОО. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны үндсэн болон нэмэлт дансны харилцах, цалингийн баримт, хүнс, эм, бараа материалын баримт, байгууллагын даргын А, Б тушаал, санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хөдөлмөрийн дотоод журам, цалингийн карт, эд хөрөнгийн тооллогын бүртгэл,

санхүүгийн тайлангийн аудит хийсэн шалгалтын материал зэрэг баримт материалуудад тулгуурлан төвийн дарга Ц.Алтантуяа, нягтлан бодогч Б.Оюунбямба, Д.Отгондаш, ахлах сувилагч Э.Бямбажаргал, нярав Б.Чинтөр нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

**7.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:**

2021 онд улсын төсвөөс 472,470.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,148.0 мянган төгрөг, ЭМДСангаас 23,000.0 мянган төгрөг нийт 540,618.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, баталсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 472,470.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,096.2 мянган төгрөг, ЭМДСангаас 18,995.3 мянган төгрөг, НДСангаас илүү шилжүүлсэн жолооч Р.Батбаярын хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 158.6 мянган төгрөг нийт 536,720.8 мянган төгрөгийн санхүүжилтын эх үүсвэр авч, урсгал зардалд 522,923.7 мянган төгрөгийг зарцуулж, харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13,797.1 мянган төгрөг байна.

**Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт:**

/мянган төгрөг/				
Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт +, Хэтрэлт-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,265.0	343,330.1	+13,934.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,230.8	45,251.8	+2,979.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,998.0	41,947.2	+50.8
2104	Хангамж, бараа материалын зардал	26,386.7	26,370.2	+16.5
2105	Нормативт зардал	42,240.0	42,236.5	+3.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,800.0	6,777.7	+22.3
2107	Томилолт, зочны зардал	1,900.0	1,898.0	+2.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,445.0	2,799.5	+645.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,353.2	11,322.9	+30.3
2132	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	1,000.0	990.0	+10.0
	<b>Дүн</b>	<b>540,618.7</b>	<b>522,923.9</b>	<b>17,694.8</b>

**Нэмэлт санхүүжилтийн дансаар:**

ЭМДЕГ-с /ковид-19 дархлаажуулалтын вакцин/ санхүүжилт 65,802.0 мянган төгрөг, ЭМДСангаас 105,213.0 мянган төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газраас 41,851.6 мянган төгрөг, Монголын сумын эмч мэргэжилтэнүүдийн холбооноос сорьц тээвэрлэсэн зардлын 39.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого /иргэдээс хандивласан 3,500.0 мянган төгрөг, оношлуурын үнэ 2,985.0 мянган төгрөг/ 6,485.0 мянган төгрөг нийт 219,391.3 мянган төгрөгийн орлого орсон байна.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшилын зардалд 19,159.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,494.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд /цэвэр бохир ус/ 763.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 3,196.4 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 5,122.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 720.0 мянган төгрөг, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд

62,382.4 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 8,000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 4,466.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 39,451.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардалд 35,200.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 32,900.0 мянган төгрөг нийт 215,237.2 мянган төгрөгийг зарцуулж, нэмэлт дансны харилцахын үлдэгдэл 4,154.1 мянган төгрөг байна.

### **7.2 Өглөг, авлагын талаар:**

Тайлант оны эцэст 4,691.6 мянган төгрөгийн өглөгтэй. Үүнд: Их илэнхэн ХХК-д хүнсний өглөг 262.7 мянган төгрөг, Хүчит жигүүр ХХК-д бараа материалын үнэ 377.9 мянган төгрөг, иргэн Ч.Насанбатад толины үнэ 132.0 мянган төгрөг, Азифарм ХХК-д эмийн өглөг 1,194.0 мянган төгрөг, Еврофарм ХХК-д эмийн өглөг 2,635.0 мянган төгрөг, аймгийн ЭМГ-т татаас санхүүжилтийн өглөг 90.0 мянган төгрөг байна.

Авлагын хувьд: ЭМЯмнаас ковидын хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээний зардлын 162,008.8 мянган төгрөг, нэмэлт дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 130.2 мянган төгрөг, Орхон НИК ХХК-иас шатахууны 1,115.2 мянган төгрөг, цалингийн авлага 50.0 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 693.0 мянган төгрөг нийт 163,997.2 мянган төгрөгийн авлагатай.

### **7.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:**

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж, орон сууц	258,120,338.76	0.00	0.00	258,120,338.76
2	Тээврийн хэрэгсэл	219,662,468.00	0.00	0.00	219,662,468.00
3	Машин тоног төхөөрөмж	56,663,857.86	74,147,715.49	4,237,291.49	126,574,281.86
4	Тавилга, эд хогшил	7,937,400.00	9,609,500.00	0.00	17,546,900.00
5	Бусад үндсэн хөрөнгө	0.00	187,500.00	0.00	187,500.00
6	Программ хангамж	0.00	1,350,000.00	0.00	1,350,000.00
7	Бусад биет бус хөрөнгө /газар/	15,050,800.00	0.00	0.00	15,050,800.00
	<b>Дүн</b>	<b>557,434,864.62</b>	<b>85,294,715.49</b>	<b>4,237,291.49</b>	<b>638,492,288.62</b>

Үндсэн хөрөнгийн дансанд төсвийн худалдан авалтаар 35,174.6 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр болон хандив тусламжаар 50,120.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 4,237.3 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна. Үүнд:

*Монбиофарм ХХК-иас* 15,000.0 мянган төгрөгөөр цусны анализатор, *Мед буян трейд ХХК-иас* 3,500.0 мянган төгрөгөөр билиметр, *Өсөх Ачлал ХХК-иас* 945.0 мянган төгрөгөөр вакцин тээвэрлэгч 50 литрийн хөргүүр сав, *Петрохими ХХК-иас* 594.0 мянган төгрөгөөр хүчилтөрөгчийн 40 литрийн баллон, *Батнаран өргөө ХХК-иас* 957.0 мянган төгрөгөөр дүш, шүршүүр, *Кэй Эс Би ХХК-иас* 5,040.0 мянган төгрөгөөр 12 ширхэг бичгийн ширээ, 1,980.0 мянган төгрөгөөр 11 ширхэг түшлэгтэй хар сандал, 310.0 мянган төгрөгөөр 1 ширхэг түшлэгтэй ногоон сандал, *БСБ электроникс ХХК-иас* 1,638.7 мянган төгрөгөөр суурин компьютер, 1,399.9 мянган төгрөгөөр проектер, *иргэн Г.Ундармаагаас* 380.0 мянган төгрөгөөр угаалгын машин, 580.0 мянган төгрөгөөр махны хөлдөөгч, 245.0 мянган төгрөгөөр усны шүүлтүүртэй аппарат /том/, 125.0 мянган төгрөгөөр усны

шүүлтүүртэй аппарат /жижиг/, *Эрдэнэ бармат ХХК-иас* 942.5 мянган төгрөгөөр вакуум хаалт, *Маргад-Орхон ХХК-иас* 187.5 мянган төгрөгөөр 125 ширхэг мод, *Си Ту Эс ХХК-д* санхүүгийн программ хангамжийн төлбөр 1,350.0 мянган төгрөг нийт 35,174.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авсан.

**ЭМЯамны хөрөнгө оруулалтаар** 850.0 мянган төгрөгийн зайнаас халуун хэмжигч 5 ширхэг, 133.3 мянган төгрөгийн амбу /нярай/ 4 ширхэг, 133.3 мянган төгрөгийн амбу /том хүн/ 4 ширхэг, 133.3 мянган төгрөгийн амбу /хүүхэд/ 4 ширхэг, 228.8 мянган төгрөгийн амбу маск /нярай, том хүний/, 586.3 мянган төгрөгийн хүүхдийн өндөр урт хэмжигч, 300.0 мянган төгрөгийн дусал тогтоогч 4 ширхэг, 2,040.0 мянган төгрөгийн яаралтай цүнх 4 ширхэг, 498.3 мянган төгрөгийн пульсоксиметр, 82.5 мянган төгрөгийн хүүхдийн даралтын аппарат, 342.1 мянган төгрөгийн хүүхдийн электрон жин, 45.1 мянган төгрөгийн амьсгал тоологч нийт 5,373.0 мянган төгрөг, **Булган аймгийн Эрүүл мэндийн газраас** 450.0 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн 40 л баллон, 93.7 мянган төгрөгийн редуктор /баллон/, 2,190.9 мянган төгрөгийн дуслын автомат шахуурга, 485.0 мянган төгрөгийн эх барихын иж бүрдлийн цомог, 2,500.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер /Dell/, 5,896.7 мянган төгрөгийн суурин компьютер /Dell Optiplex 5090SFF/, 340.3 мянган төгрөгийн вакцин тээврийн хүйтэн сав, 96.6 мянган төгрөгийн вакцин зөөвөрлөх цүнх 2 ширхэг, 2,635.5 мянган төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч 2 ширхэг, 28.5 мянган төгрөгийн пульсоксиметр, 204.0 мянган төгрөгийн пульсоксиметр 3 ширхэг, 4,789.3 мянган төгрөгийн вакцины хөргөгч нийт 19,710.5 мянган төгрөг, **сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс** 1,850.0 мянган төгрөгийн дуслын автомат шахуурга, 594.0 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн 40 литрийн баллон, 4,700.0 мянган төгрөгийн автоклав нийт 7,144.0 мянган төгрөг, “Сэлбэ ротари” клубээс 1,952.3 мянган төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч, 2,536.5 мянган төгрөгийн хяналтын монитор нийт 4,488.8 мянган төгрөг, **ОНХСангийн хөрөнгөөр** 4,999.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер 2 ширхэг **бүгд 41,716.1 мянган төгрөгийн** үндсэн хөрөнгө үнэ төлбөргүйгээр өгсөн байна.

Сумын иргэн О.Алтанзагас 480.0 мянган төгрөгийн мананцар үүсгэгч, иргэн Б.Батцэрэн 594.0 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн 40 литрийн баллон, П.Оюунцэцэг 1,100.0 мянган төгрөгийн зөөврийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч, Р.Бумбага 1,500.0 мянган төгрөгийн зөөврийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч, Базарсадын үр хүүхдүүдээс 1,400.0 мянган төгрөгийн зөөврийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч, О.Лхагважавын үр хүүхдүүдээс 3,055.0 мянган төгрөгийн шээсний анализатор, Тэшиг сумын иргэдээс 275.0 мянган төгрөгийн 20 литрийн автомакс 5 ширхэг нийт 8,404.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус хандивлажээ. Тайлант онд 4,237.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж дахин үнэлсэн байна.

#### **7.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:**

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	662,100.00	5,600,300.00	2,444,040.00	3,818,360.00
2	Аж ахуйн материал	26,568,360.34	57,275,230.00	32,254,720.00	51,588,870.34
3	Тусгай зориулалт	5,985,107.80	0.00	5,985,107.80	0.00
4	Түлш, шатах тослох	126,600.00	26,212,630.00	26,339,230.00	0.00
5	Хүнс	2,796,775.70	16,225,494.00	16,842,779.50	2,179,490.20
6	Эм, боох материал	9,428,178.00	371,497,947.54	325,202,368.00	55,723,757.54
7	Сэлбэг хэрэгсэл	1,663,100.00	433,000.00	2,096,100.00	0.00

8	Барилгын засвар	0.00	4,466,000.00	0.00	4,466,000.00
	<b>Дүн</b>	<b>47,230,221.84</b>	<b>481,710,601.54</b>	<b>411,164,345.30</b>	<b>117,776,478.08</b>

н.Анандбазарын ажлын албанаас 11,417.9 мянган төгрөгийн 300 ширхэг маск, N95 маск 200 ширхэг, түргэвчилсэн оношлуур 100 ширхэг, комбинзон 90 ширхэг, нэг удаагийн бээлий 11000 ширхэг, халад 120 ширхэг, улавч 150 ширхэг, санитос 15 ширхэг, сумын иргэн Алтангаас 832.8 мянган төгрөгийн порсон ариутгалтын бодис 6 ширхэг, комбинзон 30 ширхэг, сумдын иргэдээс /Д.Сумъяа/-аас 6,116.2 мянган төгрөгийн маск 7100 ширхэг, гар ариутгагч 25 ширхэг, найруулдаг цай 5 ширхэг, био чацаргана 55 ширхэг, нэг удаагийн улавч 40 ширхэг, комбинзон 560 ширхэг, санитол 2 ширхэг, ажилчдад витамин 25 ширхэг, кофе 3 хайрцаг **нийт 18,366.9 мянган төгрөгийн** эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, иргэн О.Солонгоос /Хутаг-Өндөр сумын иргэн Д.Болдхуяа/ 25.0 мянган төгрөгийн лууван 5 кг, төмс 30 кг хүнс тус тус хандивласан.

Аймгийн Эрүүл мэндийн газраас 243,553.1 мянган төгрөгийн вакцин, 8,231.1 мянган төгрөгийн эм, 5,467.6 мянган төгрөгийн оношлуур, 13,937.0 мянган төгрөгийн хамгаалах хувцас хэрэгсэл, пульсоксиметр, даралтын аппарат, сумын ЗДТГазраас 100.0 мянган төгрөгийн нэгжийн үнэтэй реамдизивэр /ковид-19 халдварын тариа/ тариа 20 ширхэг, 7,012.0 мянган төгрөгийн шингэн саван 8 ширхэг, халад 300 ширхэг, сальфетка 4 ширхэг, малгай 100 ширхэг, нэг удаагийн бээлий 130 ширхэг, спирт 10 ширхэг, шар уут 10 ширхэг, түргэвчилсэн оношлуур 100 ширхэг, комбинзон 100 ширхэг, маск 100 ширхэг, улавч 100 ширхэг, санитос ариутгагч 4 ширхэг, ус буцалгагч 4 ширхэг, индүү 2 ширхэг эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, хангамжийн материал үнэ төлбөргүйгээр өгсөн байна.

Сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дутагдсан 279.2 мянган төгрөгийн хүнсийг холбогдох актын дагуу барагдуулж, хүнсний материалыг 1 сарын тайлангаас зарлагдсан байна.

#### ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

1. Шаардах хуудас, орлогын баримт, хоолны өдөрлөг дугааргүй, агуулахын бүртгэл хөтлөөгүй, шаардах хуудаст олгосон материалын тоо хэмжээг, хоолны өдөрлөгт хүнсний материалын нэгжийн үнэ, бүгд дүнг бичээгүй, нягтлан бодогч няравын гаргасан хүнс, бараа материалын тайланг шалгаж хүлээн авсан ч тооцоог бодож акт үйлдээгүй.

2. Иргэдээс хандивласан бэлэн мөнгө болон оношлуурын үнийг анхан шатны баримтаар хүлээн авдаггүй, тайлан гаргаагүй.

3. Жолооч авсан шатахууны хэмжээнд тааруулан жолоочийн замын хуудсыг бичиж түүнийг үндэслэн нягтлан бодогч шатахууныг шууд зардалд тусгасан.

4. Тайлант оны эцэст эзэн холбогдогч нь тодорхойгүй цалингийн авлага 50.0 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 693.0 мянган төгрөг нийт 743.0 мянган төгрөгийн авлагатай байна.

5. Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар машин тоног төхөөрөмж 126,574.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байхад жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэлээр 109,875.4 мянган төгрөг буюу 16,698.9 мянган төгрөгөөр, тээврийн хэрэгсэл 219,662.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байхад хөрөнгийн тооллогоор 192,882.4 мянган төгрөг буюу 26,780.1 мянган төгрөгөөр зөрүүтэй. Мөн тусгай зориулалтын материалын тайланд 5,985.1 мянган төгрөгийн материал тусгагдсан ч хичнээн нэр төрлийн

материал байгаа нь тодорхойгүй байхад байгууллагын даргын тушаалаар тус тайлангийн мөнгөн дүнд тааруулж 2 төрлийн материалын нэр хийсвэрээр тавьж данс бүртгэлээс хассан.

**6.** Шилэн дансны цахим хуудсанд **2021 онд** мэдээлбэл зохих 161 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, бусад цэснээс 2-р сард мэдээлэх 1 мэдээллийг мэдээлээгүй, өмч хөрөнгөтэй холбоотой 31 шийдвэр гарсанаас 26 шийдвэрийг огт байршуулаагүй. **2022 оны 1-8-р сард** мэдээлбэл зохих 109 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 24 шийдвэрээс 19 шийдвэрийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11-д /Төсвийн байгууллага зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор ...нийтэд мэдээлнэ/ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

#### **АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 албан шаардлага үйлдэж, байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн 5 албан хаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

#### **ДҮГНЭЛТ**

Тус байгууллагын анхан шатны баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

#### **ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ**

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон холбогдох тушаал, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, актаар тогтоосон төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

**ХЯНАСАН:**

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА,  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ** **Б.БАТТУЛГА**

БИЧСЭН:  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН





